



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 21 өдөр

Дугаар 22

Улаанбаатар хот

Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг арилжааны банканд байршуулах мөнгөн хадгаламжийн 2024 оны хүүгийн доод хэмжээ батлах тухай

Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 13 дугаар зүйлийн 13.8 дахь хэсэг, Монголбанкнаас тогтоосон бодлогын хүү, арилжааны банкуудын байгууллагын хугацаатай хадгаламжийн хүүгийн дундаж хэмжээ, арилжааны банк хоорондын захын хүүгийн дундаж хэмжээг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг арилжааны банканд байршуулах мөнгөн хадгаламжийн 2024 оны хүүгийн доод хэмжээг 13.07 хувиар баталсугай.

2. Монголбанкны тухайн үеийн бодлогын хүү, арилжааны банкуудын байгууллагын хугацаатай хадгаламжийн хүүгийн дундаж хэмжээ, арилжааны банк хоорондын захын хүүгийн дундаж хэмжээний өөрчлөлттэй уялдуулан энэ тогтоолын 1 дэх хэсэгт заасан хувийг өөрчлөх тухай саналыг тухай бүр танилцуулж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Батжаргал/-т үүрэг болгосугай.

3. Тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар /Л.Мөнхзул/-т даалгасугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын алба /Г.Банзрагч/-нд үүрэг болгосугай.

5. Энэхүү тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

ДАРГА



Х.БУЛГАНТУЯА